



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 132

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.7, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Дундговь аймгийн Оюутан Залуучуудын Холбоо” ТББ-аас нутаг орныхоо оюутан залуучуудын хамтын ажиллагаа, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн харилцаа холбоо түншлэлийг өргөжүүлэх иргэд олон нийтийг биеийн тамираар хичээллэх, сагсан бөмбөгийн спортыг дэлгэрүүлэх зорилгоор “ЦОМ-2017” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Тэмцээний шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. “ЦОМ-2017” тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1000000 /нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, ня-бо /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000029